



ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ОРОН ЗАЙД БНХАУ-ЫН ОРОЛЦОО, НӨЛӨӨЛӨЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Г.Мэндхүү*, Сайханмэнд**

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D.)*

***МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн магистрант*

Түлхүүр үгс: мэдээллийн орон зай, телевиз, мэдээллийн агентлаг, зөөлөн хүчний бодлого, геополитик

Оршил. Эдийн засаг, технологи, цэргийн хүч, аж үйлдвэрлэл, соёлын хөгжлөөрөө дэлхийд тэргүүлэгч их гүрнүүдийн тоонд БНХАУ зүй ёсоор орж байгаа бөгөөд Коммунист намын удирдлагын доор энэ эрчээрээ улам бүр хөгжлөө ахиулж байна. Улс орны хөгжил дэвшлийг дагаад хэвлэл мэдээллийн салбарт ч ахиц дэвшил гарч байна. БНХАУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь нийт ард иргэдийнхээ эрэл хэрэгцээнд нийцсэн цаг үеийн тулгамдсан асуудал, сэдвээр цаг алдахгүй шуурхай мэдээлэл түгээх үүргээ нэр төртэй биелүүлж буйгаас гадна олон улсын тавцанд БНХАУ-ын нийгмийн амьдрал, ард түмний ахуй, соёл, уламжлалын тухай бодит мэдээлэл өгөхөд анхаарлаа хандуулж байна. Олон улсын мэдээллийн орон зайд БНХАУ-ын оролцоо ямар байгааг АНУ, баруун Европ, Зүүн Европ, Азийн улс орнуудын сэтгүүл зүйн салбарын судлаач эрдэмтэд ч сонирхон судалж, энэ чиглэлээр цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт зохиол, ном бичжээ. Тухайлбал, АНУ-ын эрдэмтэн Стефан Хемелрик, Майкл Кean нар 2002 онд Хятадын хэвлэл мэдээлэл: шинэ хандлага, шинэ өнцөг нэг сэдэвт бүтээл хэвлүүлж байсан бол ОХУ-ын судлаач Айиша

“Орос Хятадын хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаанд CGTN телевизийн орос хэлний сувгийн нөлөө” эрдэм шинжилгээний өгүүлэл, ӨАБНУ-ын судлаач Наледи Рамонжа, Вхонани Петла, Симхамандла Зонди нар хамтран “Технологи, мэдээлэл ба хүч: CGTN телевиз Хятад-Африкийн харилцаанд гүйцэтгэх үүрэг” эрдэм шинжилгээний өгүүлэл 2024 онд хэвлүүлж байжээ. Эдгээр судлаачид БНХАУ-ын төрөөс санхүүждэг гадаадын иргэдэд зориулан англи, франц, испани, орос, араб хэлээр нэвтрүүлэг дамжуулдаг CGTN телевизийн үйл ажиллагаа, мэдээллийн бодлого, үр нөлөөг өөр өөрсдийн өнцгөөс судалсан байна. БНХАУ-ын CGTN телевиз нь монгол хэлээр нэвтрүүлэг дамжуулдаггүй боловч кирилл үсгээр монгол хэлээр мэдээлэл түгээдэг веб сайт тогтмол ажиллуулж байна. Иймд бидний энэ судалгааны ажлын зорилго нь Хятад улс дэлхийн мэдээллийн орон зайд ямар оролцоо, байр суурийг эзэлж байгааг тодруулах, CGTN телевизийн веб сайтын монгол хэлний хувилбарын мэдээллийн онцлогийг судлахад оршиж байна.

Үндсэн хэсэг. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийг бичихдээ АНУ-ын эрдэмтэн Жозеф Най дэвшүүлж байсан “зөөлөн хүчний бодлого” үзэл баримтлалд тулгуурласан бөгөөд шинжлэх ухаанд түгээмэл ашигладаг нэгжээс ерөнхийлөн дүгнэх, түүхчлэн үзэх, харьцуулах аргыг ашиглав. Сүүлийн хорин жилд БНХАУ олон улсын тавцанд нөлөөгөө нэмэгдүүлэх зорилгоор “зөөлөн хүч” хэмээх үзэл баримтлалыг идэвхтэй ашиглаж байна. “зөөлөн хүч” (англ. “soft power”) нэр томъёог АНУ-ын улс төр судлаач Жозеф Най шинжлэх ухааны эргэлтэд оруулсан бөгөөд эдийн засгийн албадлага, цэргийн хүч хэрэглэхгүйгээр өөрийн улсын урлаг, соёл, амьдралын хэвшил, үзэл санаа, гадаад бодлогоороо бусад улс орны иргэд, төр засгийн удирдлагуудын санаа бодолд нөлөөлснөөр хүссэн үр дүндээ хүрэх чадварыг илэрхийлдэг. Хэвлэл мэдээллийн салбараар дамжуулан улс орныхоо дотоод ба гадаад бодлогоо дэлхийн бусад улс орнуудад сурталчлах, гадаадын бусад улс оронтой тогтоосон харилцаагаа бэхжүүлэх нь чухал гэдгийг дэлхийн аль ч улс орны төр засгийн удирдагчид нь ухамсарласан байдаг. БНХАУ-ын хувьд албан ёсны дипломат харилцаанаас гадна соёлын солилцоо, боловсролын салбарын тэтгэлэг, эдийн засгийн хамтын ажиллагааг дэлхийн олон оронтой хөгжүүлэхийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн салбараар дамжуулан “зөөлөн хүч”-ний бодлого явуулж байна. Гэхдээ БНХАУ “зөөлөн хүч”-ний бодлогоо хэвлэл мэдээллийн салбараар дамжуулан хэрэгжүүлэх явцад Хятадын улс төрийн тогтолцооны дотоод онцлог, дэлхийн геополитикийн нөхцөл байдалтай холбоотой хэд хэдэн сорилт, бэрхшээлтэй тулгардаг. Дэлхийн мэдээллийн орон зайд өөрийнхөө улсын эерэг дүр төрх (имиж) бүрдүүлэх тулд БНХАУ янз бүрийн арга, хэрэгсэл хэрэглэж байгаа юм.

Гадаадын уншигчдад зориулж тогтмол хэвлэл эрхлэн гаргаж байна.

Мөн гадаадын сонсогч, үзэгчдэд зориулсан 24 цагийн турш тасралтгүй ажилладаг радиостанц, телевизийн суваг ажиллуулдаг. Ийнхүү уламжлалт мэдээллийн хэрэгслээс гадна шинэ төрийн медиаг ч “зөөлөн хүч”-ний бодлогынхоо хэрэгсэл нь болгожээ. Өнөөгийн байдлаар олон улсын хэмжээнд БНХАУ-ын дуу хоолой болж байгаа гол мэдээллийн байгууллага бол “Синьхуа” агентлаг, “CGTN” сансрын хиймэл дагуулын телевиз юм. Энэ хоёр байгууллагын түүх, өнөөгийн байдлыг товч тоймлон авч үзье. Хятад улсад 1931 онд “Хун Жун шэ” нэрээр анх мэдээллийн агентлаг байгуулагдсан бөгөөд 1937 онд нэрийг нь “Синьхуа” хэмээн өөрчилжээ.

Дэлхийн хамгийн том мэдээллийн агентлагуудын тоонд зүй ёсоор нэрлэгддэг “Синьхуа” агентлаг нь өнөөгийн байдлаар дэлхийн 100 гаруй улсад байнгын сурвалжлах баг бүрэлдэхүүнтэй. (Зулькафиль М., Чойсамба Ч, 2005) Дэлхий дахинд болж байгаа үйл явдлын тухай мэдээ, сурвалжилга бэлтгэж, олон улсын мэдээлэл солилцоонд идэвхтэй оролцож байна. Мөн БНХАУ-ын тухай болон дэлхий дахинд болж байгаа сүүлийн үеийн үйл явдалд ямар байр суурьтай байгааг албан ёсоор бусад улс оронд дамжуулдаг чухал байгууллага юм. 2025 оны байдлаар Синьхуа агентлаг нь <http://www.news.cn/> вэб сайтаараа хятад, англи, орос, испани, франц, герман, португал, япон, солонгос, араб хэлээр мэдээлэл дамжуулж байна.

Синьхуа агентлаг нь 2017 оны 12 дугаар сарын 3-нд кирилл үсгээр монгол хэлээр мэдээлэл дамжуулдаг хувилбар <http://mn.news.cn/> нээсэн юм. (С.Бүрэнбаяр, 2017) Гэвч 2020 оны 8 дугаар сарын 24-өөс хойш шинэ мэдээлэл оруулахаа зогсоожээ. Өөрөөр хэлбэл, тухайн мөчөөс эхлэн “Синьхуа” агентлаг кирилл үсэг ашиглан монгол хэлээр мэдээлэл түгээдэг сайтынхаа хөгжүүлэлтийг царцаасан гэж үзэж болно. БНХАУ нь 1997 оноос гадаадын иргэдэд зориулж англи хэлээр нэвтрүүлэг дамжуулдаг CCTV-9 суваг анх байгуулсан бөгөөд 2010 онд CCTV-news хэмээн нэрийг нь өөрчилж байв. Хятадын төв телевиз (CCTV) 24 цагийн турш тасралтгүй англи хэлээр нэвтрүүлэг дамжуулдаг теле сувгийнхаа туршлагад тулгуурлан 2016 оны 12 дугаар сарын 31-ээс CGTN (China Global Television Network) гэсэн брэнд бий болгожээ. CGTN нь сансрын хиймэл дагуул ашиглаж нэвтрүүлгээ дэлхий дахинд дамжуулдаг бөгөөд англи, орос, франц, араб, испани гэсэн таван хэлээр 24 цагийн турш нэвтрүүлэг дамжуулдаг таван сувагтай. CGTN-ийн зорилго нь олон улсын үйл явдлын талаарх Хятадын байр суурийг танилцуулах төдийгүй, хятадын соёл, түүх, эдийн засаг, технологийн амжилтыг бусад улс орнуудад сурталчлах явдал юм. Тус телевизийн www.cgtn.com вэб сайт нь гадаадын 43 хэлээр мэдээлэл түгээдэг хувилбартай. CGTN телевизийн сайтын монгол хэлний хувилбар <https://mongol.cgtn.com> нь 2023 оны 12 дугаар сараас ажиллаж эхэлжээ. CGTN телевизийн веб сайтын монгол хувилбар нь өдөрт 18-22 мэдээ нэмэгдэж байна. Эдгээр мэдээг нь сэдвээр нь ангилж үзвэл Хятад ба

олон улсын харилцаа хамтын ажиллагаа, БНХАУ-ын эдийн засаг, Хятадын шинжлэх ухаан, технологийн амжилтын тухай сэдэвтэй байна. Жишээлбэл, “Ши Жиньпин Эммануэль Макронтой уулзалт хийжээ”, “Антарктид дахь Жүншань өртөөнд “ачаа буулгах” ажил явагдаж байна”, “Хятад улс алсын зайн тандан судлалын хиймэл дагуул-47-г амжилттай хөөргөлөө” гэх мэт мэдээг дурдаж болно. CGTN телевизийн веб сайтын монгол хувилбарт өдөр тутам мэдээ шинээр нэмэгдэж ордог гадна “Видео” буланд Монгол Улс ба БНХАУ-ын харилцаа, хамтын ажиллагаа, хоёр улсын түүхэнд үлдсэн бүтээн байгуулалтын тухай дүрс бичлэг цөөн тоогоор байршуулдаг.

Тухайлбал, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын “Яармагийн гүүр”, “Төв цэнгэлдэх хүрээлэн”, “1008 айлын орон сууц” зэрэг 2-3 минутын видео контентыг энд жишээ болгон дурдаж байна. Синьхуа агентлаг, CGTN нь ижил чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй өрсөлдөж, дэлхий дахинд өрнөж байгаа үйл явдлуудад өөр өнцгөөс хандах боломж бий болгож байна. “Зөөлөн хүч”-ний бодлогод ашиглагддаг өөр нэг талбар бол кино урлаг юм. Хятадын кино нийгэм, соёл, технологийн амжилт, дэвшлийг харуулсан хүүхэддэй кино, олон ангит кино, баримтат киногоор дамжуулан улсынхаа тухай эерэг ойлголт, төсөөллийг гадаадын үзэгчдэд төлөвшүүлэхээр оролдож байна. Олон улсын кино наадамд жил бүр оролцож, Netflix, Prime гэх мэт барууны орнуудын кино прокатын үйлчилгээнд хятадын уран бүтээлчдийн хийсэн киног байршуулах нь энэ стратегийн чухал хэсэг нь болоод байна. Гадаадын улс орнуудын үндэсний телевизүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, Хятадын телевизийн олон ангит киног тухай улсын хэлнээ орчуулж, мэргэжлийн түвшинд дуу оруулах ажлыг 2017 оноос хойш эрчимжүүлжээ.

Түүнээс гадна хятад хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд дэлхийн олон оронд салбартай Күнзийн төв чухал хувь нэмэр оруулж байна. Одоогийн байдлаар дэлхийн 160 улсад Күнзийн төвийн 498 салбар үйл ажиллагаа явуулж байна. Интернэтийн сүлжээ хэрэглэх нь өдөр тутмын энгийн хэрэглээ болсон өнөө цаг үед Хятад улс нийгмийн сүлжээг “зөөлөн хүч”-ний бодлого хэрэгжүүлэхдээ идэвхтэй ашиглаж байна. БНХАУ-ын нутаг дэвсгэрт. Facebook, Twitter, Youtube зэрэг нийгмийн сүлжээ, социал медиа руу хандах боломжгүй байдаг ч Хятадын төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дээр нэр дурдагдсан платформд бүртгүүлж, мэдээллийн үйл ажиллагаа явуулж байгаа юм. Хятад улсын эдийн засаг, технологийн ололт амжилт, соёлын тухай дүрс бичлэг, гэрэл зураг, бичвэр нийтэлдэг. Аялал жуучлалын маршрут, үндэсний хоол, шинэ технологийг нийгмийн сүлжээнд идэвхтэй байдаг инфлюенсер, блогчидоор дамжуулан сурталчлуулах арга өргөн ашигладаг.

Хятад улсын мэдээллийн технологийн ByteDance компанийн 2012 онд үүсгэн байгуулсан Tik-Tok нийгмийн сүлжээг дэлхийн өнцөг булан бүрд өсвөр үеийнхэн, залуусын өдөр тутам идэвхтэй хэрэглэж байна. Tik Tok нь БНХАУ-ын төрийн өмчийн хэвлэл мэдээллийн байгууллагатай шууд холбоогүй боловч, олон улсын тавцан дахь түүний амжилт нь Хятадын соёлын сэдвээр бүтээгдсэн медиа контент түгэн дэлгэрэхэд хүчтэй дэмжлэг болж байгаа юм. (Abderahman Rejeb, Karim Rejeb, Andrea Appolloni, Horst Treiblmaier, 2023) Хятад “зөөлөн хүч”-нийхээ стратегийг хэрэгжүүлэхийн тулд гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, боловсролын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй хөгжүүлж байна.

Контент солилцох, мэдээ, соёлын хөтөлбөрүүдийг хамтран бүтээх зорилгоор бусад орнуудын медиа компаниудтай түншлэлийн гэрээ байгуулдаг. Жишээлбэл, Африкийн болон Өмнөд Америкийн орнуудтай хамтарсан медиа төслүүд нь БНХАУ-ын хувьд энэ бүс нутгуудад нөлөөгөө бэхжүүлэхэд тусалдаг. Түүнчлэн БНХАУ нь хөгжиж буй орнуудын сэтгүүлчдэд зориулсан богино ба урт хугацааны сургалт, олон улсын сэтгүүл зүйн форум зохион байгуулдаг. Эдгээр хөтөлбөрүүд нь гадаадын сэтгүүлчдэд мэргэжлийнхээ ур чадварыг дээшлүүлэх боломж олгож байна. Үүний зэрэгцээ Хятадын хэвлэл мэдээллийн байгууллагууд гадаадын сэтгүүлчидтэй түншийн харилцааг шинээр бий болгож байна. “Бүс ба зам” санаачилгын хүрээнд БНХАУ-ын Засгийн Газар хөгжиж байгаа орнуудын хэвлэл мэдээллийн байгууллагуудын дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ тухайн улсын хэвлэл мэдээллийн байгууллагаар БНХАУ-д үйлдвэрлэсэн контент хэмжээ нэмэгдэж байна.

Онцлон тэмдэглэх өөр нэг зүйл нь, БНХАУ хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар улс төрийн дипломат бодлогоо хөгжүүлж байна. “Хятадын онцлогтой коммунизм” хэмээх үзэл санааг барууны либерал хөгжлийн загварын оронд сонгож болох хувилбар хэмээн хэвлэл мэдээллээр дамжуулан сурталчилж байгаа юм. Хятадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах туршлага зэргийг барууны либерал нийгэмд тулгардаг асуудалтай харьцуулан мэдээлэх нь түгээмэл байна. Соёлын дипломат харилцааны уламжлалт хэрэгслүүдийг мэдээллийн шинэ технологитой хослуулж байгааг нь Хятадын зөөлөн хүчний бодлогын гол онцлог юм. Хятадын зөөлөн хүч нь улсынхаа тухай эерэг ойлголт төлөвшүүлэхээс гадна геополитикийн ашиг сонирхол, олон улс дахь нэр хүндийг бэхжүүлэхэд чиглэсэн. Дүгнэлт ба хэлэлцүүлэг. Олон улсын мэдээллийн орон зайд БНХАУ-ын оролцоог ажиглаад дараах дүгнэлтэд хүрлээ. Нэгдүгээрт, БНХАУ уламжлалт ОНМХ-ээс гадна орчин үеийн тоон технологийг ч хамруулж чадсан том орон зайг хэвлэл мэдээллийн зах зээлд үүсгэж чаджээ. Ингэснээр Хятадын улс төр, эдийн засгийн эрх ашгийг сурталчилахаас гадна соёлын үнэт зүйлсийг ч

олон түмэнд хүргэж байна. Хоёрдугаарт, олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэх нэг тулгуур нь мэдээллийн орон зай болж байна. Хөгжиж байгаа орнуудын хэвлэл мэдээллийн салбарт хөрөнгө оруулалт хийж, олон төрлийн төслийг санхүүжүүлж байна. Гуравдугаарт, БНХАУ-ын хятадын сэтгүүлчдийн бүтээлийг хөгжиж байгаа орнуудын хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх замаар АНУ, баруун Европын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй өрсөлдөж байна. Олон улсын тавцанд БНХАУ хэвлэл мэдээллийн орон зайгаа тэлэх оролдлого нь тодорхой сорилттой тулгарч байна.

Юуны түрүүнд БНХАУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэж болох эсэх асуудал юм. Барууны ардчилал ба коммунист Хятадын хооронд үзэл суртлын, үзэл санааны ялгаа байдаг нь мэдээлэл, соёлын салбарын хамтын ажиллагаанд нь саад болдог нэг хүчин зүйл юм. Төрийн эрх баригч намын бодлого шийдвэрийг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх, эрх баригчдыг шүүмжлэхгүй байх зэрэг нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж, БНХАУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх байдлыг бууруулдаг. CGTN телевиз төдийгүй Хятадын бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрийн суртал ухуулгын хэрэгсэл гэж барууны орнууд үздэг. Ардчилсан тогтолцоотой улс орнуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хараат бус байх ёстой гэдэг зарчим баримталдаг тул энэ хүчин зүйл нь Хятадын тухай эерэг имиж төлөвшүүлэх зорилгод хүрэхэд бэрхшээл учруулдаг. Ийм сорилттой тулгарч байгаа ч БНХАУ “зөөлөн хүч”-ний бодлогоо үргэлжүүлж, олон улсын тавцанд нэр хүндээ нэмэгдүүлэхийг чармайсаар байна.

КОВИД-19 цар тахал дэгдсэн он жилүүдэд БНХАУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улсынхаа нэр төрийг хамгаалах чиглэлд идэвхтэй ажилласан. Хиймэл оюун ухаан, виртуаль бодит байдал зэрэг шинэ технологийн хөгжлийг дагаад БНХАУ-ын радио, телевиз, цахим хэвлэл нь мэдээллийн нөлөөгөө нэмэгдүүлэх шинэ боломжийг өөртөө үүсгэж байна. Шинэ медиа платформ бий болгоход хөрөнгө оруулснаар БНХАУ мэдээллийн орон зайгаа тэлж, технологид татагдсан залуу үеийн анхаарлыг өөртөө хандуулж чаджээ.

Түүнчлэн цар тахал, хүрээлэн байгаа орчны өөрчлөлт, шинжлэх ухааны шинэ нээлт, уламжлалт түүх соёлыг өвлүүлэн үлдээх гэх мэт асуудлыг БНХАУ-ын олон улсад чиглэсэн CGTN телевиз нийтлэл нэвтрүүлгийнхээ гол сэдэв болгосноор эцсийн дүндээ БНХАУ бол хүн төрөлхтөний хамтын ирээдүйг цогцлооход хариуцлагатай оролцогч, дэлхийн шинэ дэг журмыг зохион байгуулагч байж чадна гэсэн имижийг бүрдүүлж чадаж байна. БНХАУ өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нөөц бололцоог үр дүнтэй ашиглаж, дэлхийн бүс нутгийн онцлогт тааруулсан мэдээллийг орчин үеийн шинэ технологи ашиглан бэлтгэж, түгээн дэлгэрүүлснээр медиа салбарын том тоглогч нь гэж хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрч байна.

Эшлэл

- Зулькафиль М., Чойсамба Ч. *Дэлхийн сэтгүүл зүйн түүх*. 2005. х.351
- Бүрэнбаяр С. 2017. Синьхуа агентлаг Монгол улсад хандсан сайт гаргалаа. <https://mn.cctv.com/2017/12/08/ARTIdKNt0fEW62m21Ufzw8Xo171208.shtml>
- Aberahman Rejeb, Karim Rejeb, Andrea Appolloni, Horst Treiblmaier. 2023. *Foundations and knowledge clusters in TikTok (Douyin) research: evidence from bibliometric and topic modelling analyses*.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Нье, J. (2013). *What China and Russia Don't Get About Soft Power, Foreign Policy*. Paris: Power.
- Rejeb, A., Rejeb, K., Appolloni, A. (2024). Foundations and knowledge clusters in TikTok (Douyin) research: evidence from bibliometric and topic modelling analyses, *Multimed Tools – China*, 66, 141-142.
- Memon, NS, Sandano, IA. (2023). China in Africa: The Soft Power of Media Development. *Africa Development. Afrique et Développement*, 48(4), 81-102.
- Zhu, Y. (2022). China's 'new cultural diplomacy' in international broadcasting: branding the nation through CGTN Documentary. *International Journal of Cultural Policy*, 28(6), 671-683.
- Abodohoui, A., Su, Zh. (2020). Influence of Chinese managerial soft power on African skills development. *International Journal of Cultural Policy*, 40(6), 33-41.

Summary

This article analyzes the activities of the PRC media in the international arena. In recent years, the PRC has paid great attention to the media sector and is expanding the activities of television channels targeting foreign audiences. CGTN is the state television broadcaster of the PRC and broadcasts around the clock in English, Russian, French, Spanish, and Arabic. This television channel's website has a Mongolian version, where 18–22 new news items are published daily. The information policy is clearly manifested on the Mongolian version of the CGTN television channel's website. The author concludes that the CGTN television channel plays a key role in shaping the PRC's image.

Keywords: information environment, television, news agency, soft power policy, geopolitics

